

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/24/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	142
4. Аудитын илрүүлэлт	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14





Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум Тэрбэг
ЭЗД-ын Н.Баяр, Уулзвар: 7058-4200

2022.02.22 № 108

танай _____ -ны № _____ -т

ХАЛХГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.АРИУНСУВД ТАНАА

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020884



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	275,688,878.00	262,885,736.00
33	АВЛАГА	6,500,000.00	-
335	Бусад авлага	6,500,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	6,500,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	269,188,878.00	262,885,736.00
351	Түүхий эд материал	1,488,600.00	1,488,600.00
35110	Тусгай зориулалттай материал	1,488,600.00	1,488,600.00
354	Хангамжийн материал	62,116,560.00	55,813,418.00
35410	Бичиг хэргийн материал	103,000.00	103,000.00
35420	Аж ахуйн материал	57,263,560.00	50,655,418.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,000,000.00	1,530,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,750,000.00	3,525,000.00
35600	Мал амьтад	205,583,718.00	205,583,718.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,718,133,388.35	3,862,119,458.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,718,133,388.35	3,862,119,458.09
392	Биет хөрөнгө	3,710,039,185.08	3,854,364,694.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,558,515,089.03	2,558,515,089.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(198,383,251.25)	(265,877,043.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,867,379.00	314,966,379.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(156,045,845.85)	(149,496,832.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	199,220,653.00	188,663,364.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(71,020,991.48)	(79,130,456.64)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,619,924.33	168,285,924.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(63,232,531.27)	(78,932,824.07)
39209	Зам, гүүрийн байгууламж	306,496,880.00	306,496,880.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(167,577,741.62)	(181,274,840.66)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,364,465,596.00	1,675,205,957.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(499,885,974.81)	(603,056,900.89)
393	Биет бус хөрөнгө	8,094,203.27	7,754,763.23
39301	Програм хангамж	2,467,200.00	2,467,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,524,196.73)	(1,863,636.77)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,151,200.00	7,151,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,993,822,266.35	4,125,005,194.09
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,993,822,266.35	4,125,005,194.09
51	Засгийн газрын хувь оролцоо	3,993,822,266.35	4,125,005,194.09
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,421,673,069.39	1,421,673,069.39
51101	Өмч: - төрийн	1,421,673,069.39	1,421,673,069.39
512	Хуримтлагдсан үр дүн	1,897,945,472.24	2,029,128,399.98
51210	Өмнөх үеийн үр дүн	1,897,945,472.24	1,891,445,472.24

51220	Гайланта үеийн үр дүн		137,682,927.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	674,203,724.72	674,203,724.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,993,822,266.35	4,125,005,194.09



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,171,825,937.50	964,009,796.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	678,886,340.50	410,063,598.00
120	Нийтлэг татварын бус орлого	678,886,340.50	410,063,598.00
120004	Гөсөв байгууллагын өөрийн орлого	-	1,486,937.00
120004 2	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,486,937.00
120017	Үнэ төлбөргүй авсан орлого- Үндсэн хөрөнгө	663,769,737.50	406,162,061.00
120018	Үнэ төлбөргүй авсан орлого- Бараа материал	15,116,603.00	2,414,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,939,597.00	553,946,198.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	434,148,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	434,148,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,790,997.00	17,536,598.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,636,997.00	16,046,598.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,154,000.00	1,490,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	536,409,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	536,409,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	996,845,086.73	823,932,268.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	996,845,086.73	823,932,268.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	972,676,387.73	783,366,215.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,549,076.00	287,295,834.39
210101	Үндсэн цалин	264,519,700.00	287,053,172.39
210104	Урамшуулал	10,029,376.00	242,662.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,225,571.00	37,244,339.52
210201	Тэтгэврийн даатгал	23,636,771.00	24,531,163.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,647,300.00	3,138,575.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,117,700.00	2,553,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,700.00	638,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,294,100.00	6,383,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,013,280.00	25,399,272.00
210301	Гэрэл, цахилгаан	4,482,880.00	4,102,272.00
210302	Үүлш, халаалт	14,134,400.00	20,297,000.00

210303	Цэвэр, бохир ус	396,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,267,208.00	42,452,678.00
210401	Бичиг хэрэг	3,303,100.00	4,257,300.00
210402	Тээвэр, шатахуун	27,495,971.00	24,560,836.00
210403	Шүүдан, холбоо, интернэтийн төлбөр	2,255,000.00	3,950,000.00
210404	Ном, хэвлэл	615,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	459,000.00	480,000.00
210408	Бараа материал акталсны зардал	14,139,137.00	8,724,542.00
2105	Нормативт зардал	321,650.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	321,650.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	8,965,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	46,800.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	8,919,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,334,700.00	8,380,000.00
210702	Дотоод албан томилолт	6,334,700.00	5,880,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,243,500.00	3,095,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,448,400.00	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	815,900.00	430,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	150,000.00
210807	Газрын төлбөр	145,700.00	290,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	583,721,402.73	370,533,291.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	86,668,650.00	106,848,510.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	497,052,752.73	263,684,781.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,168,699.00	40,566,053.09
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,168,699.00	40,566,053.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,168,699.00	40,566,053.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	174,980,850.77	140,077,527.74
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	8,393,881,393.68	2,394,600.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	8,393,881,393.68	-
225001 1	Үнэ төлбөргүй гарсан зардал- Бараа материал		2,394,600.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(8,393,881,393.68)	(2,394,600.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(8,218,900,542.91)	137,682,927.74



2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,125,546,015.15	12,221,422,809.26
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-8,700,000.00	-8,700,000.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,116,846,015.15	12,212,722,809.26
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,116,846,015.15	12,212,722,809.26
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,116,846,015.15	12,212,722,809.26
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-6,500,000.00	-6,500,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,110,346,015.15	12,206,222,809.26
D08	Тайлант үеийн үр дүн			137,682,927.74	137,682,927.74
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,421,673,069.39	674,203,724.72	10,248,028,942.89	12,343,905,737.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	492,939,597.00	555,433,135.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	1,486,937.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	1,486,937.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,486,937.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,486,937.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,939,597.00	553,946,198.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	434,148,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	434,148,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	58,790,997.00	17,536,598.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	37,636,997.00	16,046,598.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,154,000.00	1,490,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		536,409,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	536,409,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	492,939,597.00	555,433,135.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	492,939,597.00	555,433,135.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	468,770,898.00	514,867,081.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,549,076.00	287,295,834.39
210101	Үндсэн цалин	264,519,700.00	287,053,172.39
210104	Урамшүүлал	10,029,376.00	242,662.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,225,571.00	37,244,339.52
210201	Тэтгэврийн даатгал	23,636,771.00	24,531,163.79
210202	Тэтгэмжийн даатгал	2,647,300.00	3,138,575.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,117,700.00	2,553,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,700.00	638,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,294,100.00	6,383,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,013,280.00	25,399,272.00
210301	Гэрэл, цахилгаан	4,482,880.00	4,102,272.00
210302	Түлш, халаалт	14,134,400.00	20,297,000.00
210303	Цэвэр, бохир ус	396,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,128,071.00	33,728,136.00
210401	Бичиг хэрэг	3,303,100.00	4,257,300.00
210402	Тээвэр, шатахуун	27,495,971.00	24,560,836.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,255,000.00	3,950,000.00
210404	Ном, хэвлэл	615,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	459,000.00	480,000.00
2105	Нормативт зардал	1,021,650.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,021,650.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,620,000.00	10,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,620,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	9,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,334,700.00	8,380,000.00
210702	Дотоод албан томилолт	6,334,700.00	5,880,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,243,500.00	3,095,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,448,400.00	2,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	79,500.00	159,000.00

210804	Иэврийн хэрэгслийн татвар	815,900.00	430,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	150,000.00
210807	Газрын төлбөр	145,700.00	290,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,635,050.00	109,074,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,635,050.00	109,074,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,168,699.00	40,566,053.09
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,168,699.00	40,566,053.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,168,699.00	40,566,053.09
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		


2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	537,279,600.00	497,330,483.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	537,279,600.00	497,330,483.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	537,279,600.00	497,330,483.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,735,800.00	287,053,172.39
210101	Үндсэн цалин	301,735,800.00	287,053,172.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,161,100.00	37,244,339.52
210201	Тэтгэврийн даатгал	26,395,000.00	24,531,163.79
210202	Тэтгэмжийн даатгал	3,191,500.00	3,138,575.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,553,200.00	2,553,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	638,300.00	638,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,383,100.00	6,383,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,683,000.00	25,399,272.00
210301	Гэрэл, цахилгаан	4,386,000.00	4,102,272.00
210302	Түлш, халаалт	20,297,000.00	20,297,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	28,104,200.00	28,104,200.00
210401	Бичиг хэрэг	4,007,300.00	4,007,300.00
210402	Тээвэр, шатахуун	19,236,900.00	19,236,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,900,000.00	3,900,000.00
210404	Ном, хэвлэл	480,000.00	480,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд аүйлс	480,000.00	480,000.00

2105	Нормативт зардал	200,000.00	200,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,450,000.00	10,450,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	800,000.00
210604	Урсгал засвар	9,650,000.00	9,650,000.00
2107	Томилолт, зочны зардал	8,380,000.00	8,380,000.00
210702	Дотоод албан томилолт	5,880,000.00	5,880,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,500,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,161,000.00	3,095,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,000,000.00	2,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	159,000.00	159,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	430,000.00	430,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	150,000.00
210807	Газрын төлбөр	290,000.00	290,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,404,500.00	97,404,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,404,500.00	97,404,500.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	497,330,483.91	497,330,483.91
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,330,483.91	497,330,483.91
132001	Орон нутгийн төсвөөс	497,330,483.91	497,330,483.91

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,536,598.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,536,598.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,536,598.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,662.00
210104	Урамшуулал	242,662.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,623,936.00
210401	Бичиг хэрэг	250,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,323,936.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	50,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,670,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,670,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,536,598.00
310001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	7,536,598.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Халхгол сумын Засаг даргын тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/45 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, улсын бодлого мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Халхгол сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 01 дүгээр тушаалаар томилогдсон Дотоод хяналтын баг нь төлөвлөгөө боловсруулан батлуулж, хагас бүтэн жилээр биелэлтийг тайлагнан ажилладаг байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халхгол сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,



материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 996.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, 8.2 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 262.9 сая төгрөг болж 6.3 сая төгрөгөөр буурсан төсвийн хөрөнгөөр 136.9 сая төгрөгийн худалдан авалт хийж, 2.4 сая төгрөгийн бараа материал хандиваар хүлээн авч, 145.6 сая төгрөгийн бараа материал тайлант онд зарцуулсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,221.7 сая төгрөг болж 345.9 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1.5 сая төгрөгийн худалдан авалт хийж, аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгө оруулалтаар 406.1 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч, 61.7 сая төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 207.8 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 172.9 сая төгрөгөөр буурсан бараа үйлчилгээний бусад зардал буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 616.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 616.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 537.3 сая төгрөгийн төсөв баталсан бөгөөд 536.4 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 0.9 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 536.4 сая, үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 497.3 сая төгрөг буюу 92.5 хувийн гүйцэтгэлтэй байна. 40.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбоогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 16.0 сая нийт 17.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хагас жилийн мал тооллого, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хяналт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Халхгол сумын Засаг даргын тамгын газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2021 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 6.5 сая төгрөгийн албан шаардлага, 0.5 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.



3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 32.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 0.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, орлогодсон нь төлбөрийн баримтын цахим систем дэх баримттай нэр төрлийн хувьд зөрүүтэй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтын НХМаягт ТМ-5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.....Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.2 Албан шаардлага

Тогтмол бус үйл ажиллагаа явуулдаг хувь хүнээс бараа материал авахдаа НӨАТ-ын баримт шивүүлэхгүй, татварын 10 хувийг суутган төлж гүйлгээ хийж байгаа нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.2.Тогтмол бус үйл ажиллагаа эрхэлж олсон орлогыг үйл ажиллагааны орлогод хамруулна, 15.1. Үйл ажиллагааны орлогод албан татварыг ногдуулах орлогыг тодорхойлохдоо Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1-д заасан шаардлагыг хангасан зардлыг хасаж, гэж заасныг хэрэгжүүлэхгүй байна

Төрийн сангийн гүйлгээ хийхдээ НӨАТ-ын баримт хавсаргахгүй, өөр өдөр нөхөж шивүүлсэн байгаа нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтын НХМаягт ТМ-5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.....Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халхгол сумын Засаг даргын тамгын газар	3	32.6			1	0.9	2	31.7		